МЭДЭЭ · 2022 оны 4-р сарын 18

ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН ЗӨВӨЛГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



Дундговь аймгийн прокурорын газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Шүүх, Хүний эрхийн комиссын референт, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Тагнуулын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба, аймгийн засаг даргын Тамгын газрын хууль эрх зүйн хэлтэс, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Авто тээврийн төвийн төлөөллүүд болон аймгийн 15 сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан салбар зөвлөлийн гишүүдийг оролцуулан нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулжээ.

Зөвлөгөөнөөр аймгийн прокурорын газраас аймгийн эрүүгийн болон зөрчлийн гаралт, шалтгаан нөхцөл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын чанар, үр дүнг сайжруулах, хүний эрх, эрх чөлөө, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх чиглэлээр мэдээлэл хийж, анхаарах асуудлын талаар харилцан ярилцаж, санал солилцож, зөвлөмж гаргасан байна.

Зөвлөмжид гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын уялдаа холбоо, үр дүнг сайжруулж аймгийн хэмжээнд нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад чиглэсэн ажил,

арга хэмжээг тогтмол зохион байгуулахаар тусгасан юм.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2469